МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 10

СУМДЫН ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭДҮҮЛЭГ АВАХ ӨРӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦЖЭЭ



Увс аймгийн прокурорын газраас Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Хяргас, Малчин сумдад ажиллаж, сумдын хэсгийн төлөөлөгчийн мэдүүлэг авах өрөө Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн А/57 дугаар тушаалаар батлагдсан "Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага"-д нийцэж байгаа эсэхтэй танилцлаа.

Тус шаардлагад "Мэдүүлэг авах ажиллагаанд ашиглагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг тухай бүр нь хуулбарлан авах, хадгалах боломжтой төхөөрөмжийг ашиглах бөгөөд бичлэгийг засварлах, устгах зэрэг эрсдэлээс бүрэн хамгаалсан байна" гэж заасан байдаг.

Сумдын хэсгийн төлөөлөгчийн мэдүүлэг авах өрөөнд теле хяналтын камерыг байршуулах, мэдүүлгийн үеийн дуу, дүрсийг чанартай бичих, бичлэгийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар аймгийн Цагдаагийн газарт албан бичиг хүргүүлжээ.

Мөн прокурорын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, гэмт хэрэг,

зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээрх сумдын иргэдтэй уулзаж, тухайн сумуудад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч ажилласан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1099